

## **МЭДЭЭЛЭЛ**

### **ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХЭД ТУСЛАХ**

Австри улсад орон сууц түрээслэхэд түрээсийн төлбөр, барьцаа мөнгө шаардагдана.

#### **Түрээсийн төлбөр**

Түрээсийн төлбөр гэдэг нь орон сууц түрээсэлсний төлөө таны төлж буй мөнгө юм.

Та сар бүр түрээсийн төлбөрөө төлж байх ёстой.

Түрээсийн төлбөр нь сар бүр ижил дүнтэй байна.

#### **Барьцаа**

Барьцаа нь 3 хүртэлх сарын түрээсийн төлбөртэй ижил дүнтэй байна.

Та барьцааг нэг л удаа буюу түрээсэлж эхлэхээс өмнө төлөх ёстой.

Барьцаа нь түрээслүүлэгчид төлж буй баталгаа юм.

Үүнийг шаардлагатай засварт зориулна

Эсвэл та түрээсээ төлөөгүй үед ашиглана.

#### **Барьцаа хөрөнгийн зээл**

Танд барьцаа өгөхөөр хангалттай хэмжээний мөнгө байна уу?

Байхгүй бол, Доод Австрийн муж нь танд тусалцаа үзүүлнэ.

Доод Австрийн муж нь барьцаанд тавих мөнгийг зээлэх боломжтой.

Үүнийг “барьцаа хөрөнгийн зээл” гэж нэрлэнэ.

Та энэхүү мөнгийг эргүүлэн төлөх үүрэгтэй боловч энэхүү зээлийн хүүг төлөх үүрэггүй.

#### **Хэн барьцаа хөрөнгийн зээлийг авах боломжтой вэ?**

- ▶ Австрийн иргэншилтэй хүмүүс.
- ▶ Улс төрийн цагаачлах эрх авсан хүмүүс.

Бусад хүмүүс удирдах газартай холбоо барих шаардлагатай.

#### **Барьцаа хөрөнгийн зээл авах боломжгүй байх**

- ▶ Улс төрийн цагаачлах эрх хүссэн хүмүүс.
- ▶ Олон улсын улс төрийн цагаачлах эрх авсан хүмүүс.  
Улс төрийн цагаачлах эрх аваагүй боловч эх орноосоо гараагүй байгаа хүмүүс.

## **Барьцаа хөрөнгийн зээлийг хэрхэн авах вэ?**

Та **өргөдөл** гаргах ёстой.

Та интернэт дээр дараах хаягаас өргөдлийн маягтыг авч болно:

[http://www.noel.gv.at/Gesellschaft-Soziales/Sozialhilfe/Sozialleistungen/Sozialhilfe\\_Hilfe\\_in\\_besonderen\\_Lebenslagen.html](http://www.noel.gv.at/Gesellschaft-Soziales/Sozialhilfe/Sozialleistungen/Sozialhilfe_Hilfe_in_besonderen_Lebenslagen.html)

**Санамж:** Та УРЬДЧИЛАН өргөдлөө бөглөж, зөвшөөрөл өгөхийг хүлээх ёстой. Та зөвшөөрөл авсны ДАРАА түрээсийн гэрээнд гарын үсэг зурж болно.

**Та эхлээд түрээсийн гэрээнд гарын үсэг зураагүй бол та барьцаа хөрөнгийн зээлийг авч чадахгүй.**

Маягтыг бөглөнө үү.

Өргөдлөө дараах зохих удирдах байгууллагад илгээнэ:

- ▶ Дүүргийн удирдах байгууллага,  
Дүүргийн удирдах байгууллага, хотын удирдах байгууллага, эсвэл
- ▶ Орон нутгийн удирдах газар буюу оршин суугаа газрын захиргаа

Та барьцаа хөрөнгийн зээл авах боломжтой эсэхийг тухайн удирдах газар шийднэ.

Та дараах тохиолдолд зөвхөн зээл авна

Танд **нэг удаа** туслалцаа хэрэгтэй бол.

Өөрөөр хэлбэл: та үүний дараа **амьжиргааны зардлаа өөрөө төлөх** чадвартай байх ёстой.

Танд түрээс, тог цахилгаан, хүнс, хувцас зэрэгт зориулах хангалттай мөнгө байх ёстой.

Барьцаа хөрөнгийн зээл нь танд бодитоор шаардлагатай мөнгөн дүн юм.

Энэ нь зөвхөн **онцгой тохиолдолд** ашиглагдана.

Барьцаа хөрөнгийн зээлийг авах **автомат эрх** гэж байдаггүй.

Удирдах газар нь танаас олон төрлийн зүйл шаардана.

## **Барьцаа хөрөнгийн зээлийг авахад тань юу шаардагдах вэ?**

- ▶ Та **бүх асуултуудад хариулах** ёстой.
- ▶ Та **бүх чухал баримт бичгийг** ирүүлэх ёстой.
- ▶ Та удирдах газарт өөрийн **хөрөнгө, орлогын** талаар **хэлэх** ёстой.  
Таны хөрөнгө гэдэгт таны эзэмшиж буй бүх зүйлс орно.  
Таны орлого гэдэгт таны олж буй, хүлээн авч буй бүх зүйлс орно.  
Удирдах байгууллага нь танай гэр бүлийн төсвийг тооцно.  
Удирдах байгууллага нь таны нийгмийн байдлын тайланг гаргана.  
Удирдах байгууллагын төлөөлөл нь танай гэрт зочилно.
- ▶ Та өөрийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд **өөрөө өөртөө туслах** ёстой.  
Доорх жишээний дагуу та барьцаа хөрөнгийн зарим хэсгийг өөрөө төлж болно.

Та нүүх асуудлаа өөрөө хариуцаж болно.  
Та шаардлагатай бол түрээслүүлэгчтэйгээ ярилцаж болно.

- ▶ Дараа нь та мөнгөтэй болбол,  
Та **удирдах байгууллагад** мэдэгдэх ёстой.
- ▶ Та өөрийн авах эрх бүхий **бусад бүх төрлийн санхүүгийн туслалцаа дэмжлэгийг** шаардах ёстой. Жишээлбэл, үүнд орон сууцны олговор, орон сууцны туслалцаа орно.

### Хэн мөнгө хүлээн авах вэ?

- ▶ Барьцаа хөрөнгийн зээлийн мөнгө нь байнга **түрээслүүлэгч рүү ШУУД** шилждэг.
- ▶ Та **амлалтын бичигт** гарын үсэг зурах ёстой.  
Та Доод Австрийн мужид энэхүү мөнгийг эргүүлэн төлөх ёстой гэдгийг энэхүү бичиг батална.
- ▶ Та **үүрэг оноосон баримт бичигт** гарын үсэг зурах үүрэгтэй.  
Энэхүү баримт бичигт түрээслүүлэгч нь  
Таныг орон сууцнаас гарсан үед уг мөнгийг Доод Австрийн мужид эргүүлэн төлнө гэж заасан байдаг.

### Та барьцаа хөрөнгөө хэрхэн эргүүлэн төлөх вэ?

- ▶ Хэрэв түрээслүүлэгч нь мөнгийг эргүүлэн төлөөгүй бол та Доод Австрийн мужид барьцаа хөрөнгийн зээлийг эргүүлэн төлөх үүргийг хүлээнэ.  
Амлалтын бичиг нь дараах тайлбарыг агуулна:  
Хэзээ, хэр хэмжээгээр та мөнгө төлөх ёстой.  
Та орон сууцнаас гарсан үед,  
Та бүх мөнгөн дүнг эргүүлэн төлөх ёстой.
- ▶ Үүрэг оноосон бичигт дараах тайлбар байна:  
Түрээслүүлэгч нь таныг нүүсний дараа барьцаа хөрөнгийг эргүүлэн төлнө.  
Түрээслүүлэгч нь барьцаа хөрөнгийг удирдах байгууллагад шууд төлнө.
- ▶ Дараах тохиолдолд түрээслүүлэгч нь барьцаа хөрөнгийг эргүүлэн **ТӨЛӨХГҮЙ**:
  - \* та түрээсээ төлөөгүй бол
  - \* засвар хийх шаардлагатай бол
  - \* та ямарваа эвдрэл гэмтэл учруулсан бол.Ийм тохиолдолд, та өөрөө **Доод Австрийн мужид барьцаа хөрөнгийг өөрөө** эргүүлэн төлөх үүрэг хүлээнэ.

### Анхааруулга! Чухал санамж:

- ▶ Та сар бүр түрээсийн төлбөрөө төлж чадах тохиолдолд зөвхөн орон сууц түрээслэх
- ▶ Түрээсийн гэрээ байгуулсан үед зөвхөн орон сууц түрээслэх.  
Түрээсийн гэрээ байгуулаагүй бол, амьжиргааны баталгаажих доод түвшинтэй холбоотой асуудлууд үүсэж болох юм.

- ▶ Даатгалын гэрээ, зурагт, интернэт, гар утас, худалдан авалттай холбоотой гэрээний заалтыг оруулна. Та дээрхийг сар бүр төлөх үүрэгтэй.
- ▶ Дансанд байгаагаасаа илүү мөнгийг зарцуулахгүй байх.
- ▶ Аливаа эд зүйлсийг авахдаа үнэд нь анхаарал тавих.  
Хуучин эдлэлийн дэлгүүрээр үйлчлүүлэх:  
Тус дэлгүүрийн ихэнх бараа шинэ биш боловч тэдгээр нь үнэтэй биш байдаг.
- ▶ **Сар бүр, түрээс, цахилгаан, халаалтаа юуны түрүүнд төлж байх.**